

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

**2024 оны 06 дугаар сарын 04-ний өдөр, Мягмар гараг**

**Хуралдааны тэмдэглэлийн агуулга**

**Хуралдааны товч тэмдэглэл:** 1-2

**Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:** 3-7

---

1.Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллагын эрх ямба, дархан эрхийн тухай конвенцын XV хавсралтыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.05.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх, хэлэлцүүлэх/ 3-4

2.Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай ЮНИДРУА /Хувийн эрх зүйг нэгтгэх олон улсын хүрээлэн/-ийн конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/ 4-7

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы  
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны  
06 дугаар сарын 04-ний өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 17 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 52.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 52 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Ганбат, Б.Дэлгэрсайхан;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, П.Анужин, Д.Цогтбаатар, Ж.Эрдэнэбат;

Эмнэлгийн чөлөөтэй: Г.Амартүвшин, С.Батболд.

**Нэг.Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллагын эрх ямба, дархан эрхийн тухай конвенцын XV хавсралтыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.05.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх, хэлэлцүүлэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Соёлын сайд Ч.Номин, Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын захирал С.Сүхболд, мөн газрын дэд захирал Ж.Соёлмаа, Оюуны өмчийн газрын Аж үйлдвэрийн газрын дарга С.Урангэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ж.Түвшинжаргал, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, мөн хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан референт Б.Гандиймаа нар байлцав.

Хуулийн төслийн талаар Соёлын сайд Ч.Номин танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Б.Энх-Амгалан:** Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллагын эрх ямба, дархан эрхийн тухай конвенцын XV хавсралтыг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 2

Бүгд: 9

77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.

**Хоёр.Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай ЮНИДРУА/Хувийн эрх зүйг нэгтгэх олон улсын хүрээлэн/-ийн конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Соёлын сайд Ч.Номин, Соёлын яамны Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Даваацэрэн, мөн яамны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга С.Батцэцэг, Соёлын өвийн үндэсний төвийн дарга Г.Энхбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, мөн хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан референт Б.Гандиймаа нар байлцав.

Хуулийн төслийн талаар Соёлын сайд Ч.Номин танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн тавьсан асуулгад Соёлын сайд Ч.Номин, Соёлын яамны Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Даваацэрэн нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан үг хэлэв.

**Б.Энх-Амгалан:** Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай ЮНИДРУА /Хувийн эрх зүйг нэгтгэх олон улсын хүрээлэн/-ийн конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 2  
Бүгд: 9  
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 12 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 15 минут үргэлжилж, ирвэл зохих 17 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 52.9 хувийн ирцтэйгээр 12 цаг 07 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
АЮУЛГҮЙ БАЙДАЛ,  
ГАДААД БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХ-АМГАЛАН

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 06 дугаар сарын 04-ний өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Их засаг” танхим  
11 цаг 52 минут.

### АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Б.Энх-Амгалан:** Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2024 оны 6 сарын 4-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Бямбасүрэнгийн Энх-Амгалан ирсэн, Норовын Алтанхуяг ирээгүй байна. Ганибалын Амартүвшин гишүүн өвчтэй байна. Пүрэв-Очирын Анужин гишүүн чөлөөтэй байна. Хавдисламын Баделхан гишүүн ирсэн байна. Энхтайваны Бат-Амгалан гишүүн ирсэн байна. Баагаагийн Баттөмөр гишүүн ирсэн байна. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна. Сүхбаатарын Батболд гишүүн өвчтэй байна. Дашдондогийн Ганбат гишүүн чөлөөтэй байна. Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн орон нутагт томилолттой байна. Нанзадын Наранбаатар гишүүн ирсэн байна. Салдангийн Одонтүяа гишүүн ирсэн байна. Цэдэвийн Сэргэлэн гишүүн ирсэн байна. Дамдины Цогтбаатар гишүүн чөлөөтэй байна. Нямаагийн Энхболд гишүүн ирсэн байна. Жаргалтулгын Эрдэнэбат гишүүн чөлөөтэй байна.

Гишүүдийн ирцийг танилцуулж дууслаа. Хэлэлцэх асуудалдаа оръё. Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх 2 асуудал байна. Нэг дэх нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллагын

эрх ямба, дархан эрхийн тухай конвенцын 15 дугаар хавсралтыг Соёрхон батлах тухай хуулийн төсөл, Засгийн газар 2024 оны 5 сарын 28-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх хэлэлцүүлэх. 2.Хулгайлагдсан эсвэл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай ЮНИДРУА-гийн хувийн эрх зүйг нэгтгэх олон улсын хүрээлэнгийн конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл, Засгийн газар 2024 оны 5 сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал батлагдлаа.

**Нэг.Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллагын эрх ямба, дархан эрхийн тухай конвенцын XV хавсралтыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.05.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх, хэлэлцүүлэх/**

1 дүгээрт НҮБ-н төрөлжсөн байгууллагын эрх ямба, дархан эрхийн тухай конвенцын 15 дугаар хавсралтыг Соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцье. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. 1 дүгээрт Засгийн газрын гишүүн, Соёлын сайд Чинбатын Номин, Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын захирал Сүхээгийн Сүхболд, Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын дэд захирал Жамбалдоржийн Соёлмаа, Оюуны өмчийн газрын Аж үйлдвэрийн газрын дарга Сумъяагийн Урангэрэл нар оролцож байна. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулж дууслаа.

Хуулийн төслийн талаарх танилцуулгыг Засгийн газрын гишүүн, Соёлын сайд Чинбатын Номин танилцуулна. Номин сайдын микрофоныг өгье.

**Ч.Номин:** Эрхэм байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

НҮБ-ын төрөлжсөн байгууллагын эрх ямба, дархан эрхийн тухай 1947 оны конвенц нь НҮБ-ын төрөлжсөн байгууллага бүрийн эрх ямба, дархан эрхийн асуудлыг зохицуулдаг бөгөөд Монгол Улс уг конвенцыг 1970 онд соёрхон баталсан. Дэлхийн оюуны өмчийн байгууллагад 1974 онд НҮБ-ын төрөлжсөн байгууллагын статусыг олгож, улмаар дээрх конвенцын 15 дугаар хавсралтаар түүний эрх ямба, дархан эрхийг шинээр баталгаажуулжээ.

Монгол Улс Дэлхийн оюуны өмчийн байгууллагад 1979 онд гишүүнээр элсэн орж, уг байгууллагатай идэвхтэй хамтын ажиллагаа хэрэгжүүлж ирсэн хэдий ч НҮБ-ын төрөлжсөн байгууллагын эрх ямба, дархан эрхийн тухай конвенцын 15 дугаар хавсралтад нэмэлтээр соёрхон батлаагүй байна. НҮБ-ын төрөлжсөн байгууллагын эрх ямба, дархан эрхийн тухай конвенцын 15 дугаар хавсралтыг соёрхон баталснаар 1 дүгээрт Монгол Улсын суурь конвенцын дагуу 1970 оны хүлээсэн онд хүлээсэн үүргээ биелүүлэх, 2 дугаарт Дэлхийн оюуны өмчийн байгууллага болох болон түүний Монгол Улс дахь үйл ажиллагаа аливаа саад тотгоргүй, илүү идэвхтэй өрнөх эрх зүйн суурь тавигдана.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 76.1 дэх хэсэгт заасны дагуу конвенцын хавсралтыг соёрхон батлах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

**Б.Энх-Амгалан:** Номин сайдад баярлалаа. Хуулийн төслийн талаарх танилцуулгыг хийж дууслаа. Хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү? Алга байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү? Үг хэлэх юм уу? Үг гишүүн алга байна. Гишүүд үг хэлж дууслаа.

Санал хураалт явуулъя. Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллагын эрх ямба, дархан эрхийн тухай конвенцын 15 дугаар хавсралтыг Соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүдээ. Санал хураалтад 9 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжиж, 77,8 хувийн саналаар уг санал дэмжигдлээ. Санал хураалтын дүнг танилцуулж дууслаа. Хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар танилцуулъя.

11.57 цаг

**Хоёр.Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай ЮНИДРУА /Хувийн эрх зүйг нэгтгэх олон улсын хүрээлэн/-ийн конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/**

Дараагийн асуудалдаа оръё. Ажлын хэсгийнхэнд баярлалаа. Хулгайлагдсан эсвэл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай ЮНИДРУА Хувийн эрх зүйг нэгтгэх олон улсын хүрээлэнгийн конвенцыг Соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. 1.Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёлын сайд Чинбатын Номин, Соёлын яамны Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Бямбасүрэнгийн Даваацэрэн, Соёлын яамны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Содномжамцын Батцэцэг, Соёлын өвийн үндэсний төвийн дарга Галбадрахын Энхбат нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг оролцож байна. Ажлын хэсгийг танилцуулж дууслаа.

Хуулийн төслийн талаарх танилцуулгыг Засгийн газрын гишүүн,

Соёлын сайд Чинбатын Номин танилцуулна. Номин сайдын микрофоныг өгье.

**Ч.Номин:** Байнгын хороон дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд соёрхон батлагдахаар заасан Хулгайлагдсан эсвэл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай ЮНИДРУАгийн конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг ЗГ-аас 2024 оны 5 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Энэхүү конвенц нь хулгайлагдсан эсхүл хууль бусаар хилээр нэвтэрсэн соёлын эд зүйлсийг эгүүлэн олгох болон буцаан авах талаар хувийн эрх зүйн хүрээнд улс хоорондын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хөнгөвчлөх, хөнгөвчлөхөд чиглэгддэг олон улсын эрх зүйн баримт бичиг юм. Конвенц нь 5 бүлэг, 21 зүйл, хавсралтаас бүрддэг бөгөөд өнөөдрийн байдлаар дэлхийн 54 улс конвенцод нэгдэн орсон байна.

Хулгайлагдсан эсвэл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай ЮНИДРУАгийн конвенцод Монгол Улсын 1991 онд нэгдэн орсон ЮНЕСКОгийн 1970 оны соёлын үнэт зүйлийг хууль бусаар хилээр гаргах, оруулах, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай конвенцын дутуу эсхүл зохицуулагдаагүй үлдээсэн зарим асуудлыг нарийвчлан тусгаж өгснөөрөө онцлог юм.

Тухайлбал, хулгайлагдсан, эсвэл хууль бусаар хилээр нэвтэрсэн эд зүйлийг нэхэмжлэх хугацаа, уугуул оршин суугчдын соёлын эд зүйлийг өмчлөх эрх, нөхөн төлбөрийг нөхцөл, өмчлөх эрхийг тогтоох үйл ажиллагаа зэргийг нарийвчлан тусгасан байдаг. Конвенцыг соёрхон баталснаар Монгол Улсыг хөгжүүлэх урт, дунд хугацааны хөгжлийн

бодлого болон Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал, Соёлын өвийн хууль, Соёлын өвийн хууль бусаар худалдаалахтай тэмцэх талаар заасан зорилт, арга хэмжээний хүрээнд соёлын эд зүйлийг эгүүлэн олгох болон буцаан буцаах чиглэлээр бусад улстай хамтран ажиллах боломжийг өргөжүүлэхээс гадна олон улсын эрх зүйн хүрээнд соёлын өвийн хууль бус худалдаатай үр дүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх эрх зүйн орчин боловсронгуй болно гэж үзэж байна.

Конвенцыг соёрхон баталснаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн хүрээнд сөрөг үр дагавар гарахгүй ба шинээр өөр хууль боловсруулах, бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй, эсвэл хүчин төгөлдөр хуулиуд хүчингүй болгохгүй болно. Хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

**Б.Энх-Амгалан:** Номин сайдад баярлалаа. Хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү? Би нэг асуулт асууя. Энэ сүүлийн 5 жилд буюу 2017-гоос 2021 оны хооронд хулгайлах гэмт хэргийн улмаас 52 түүх соёлын дурсгалт зүйл алга болсон. 22 түүх дурсгалын зүйлсийг эрэн сурвалжилж олсон ба 30 ширхэг түүх дурсгалын зүйл олдоогүй эрэн сурвалжилж байна гэсэн мэдээ байна.

Соёлын биет өвийн эсрэг гэмт хэргийн тоо сүүлийн үед буурахгүй, 2021 онд гэхэд 3, 2022 онд гэхэд 9, 2023 онд гэхэд 19 ийм хэрэг бүртгэгдсэн байна. Тэгэхээр цаашидаа олон улсын энэ конвенцод нэгдсэнээр гадаад руу гарч байгаа ийм түүх соёлын, дурсгалт өв, үнэт өвүүдийг эргүүлэн олох ажил энэ конвенцоор баталгаажна гэж ойлгож байна. Зөв үү 1 дэх нь?

2 дахь нь үүнтэй холбогдуулан дотоодын хууль тогтоомжийн хүрээнд хамгаалагдах ёстой хууль тогтоомжид өөрчлөлт оруулах ийм шаардлага хэрэгцээ бий юу. Ийм 2 асуултад хариулт хэлж

өгөөч? Хэн хариулах вэ? 2 номер Номин сайдын микрофоныг өгье.

**Ч.Номин:** Энх-Амгалан гишүүний асуултад хариулъя. Би эхлээд хариулаад бас манай ажлын албанаас нэмэлт хариулт өгнө. 1 дүгээрт яг төрийн өмчийн музей болон төрийн өмчийн бүртгэлд байгаа ямар нэгэн сан хөмрөгөөс бол аливаа зүйл сүүлийн жилүүдэд бол алдагдаагүй байгаа. Манай сан хөмрөгийн бүртгэл болон түүнээс гадна хадгалалт, хамгаалалт сайжирсан. Таны дурдсан сүүлийн 3 жилд хулгайлагдсан зүйлүүд бол дандаа сүм хийдээс хулгайлагдсан зүйлүүд байгаа. Тэгэхдээ улсын бүртгэлд байдаг зүйлүүд байгаа.

Өнөөдрийн байдлаар бол бид бүхэн соёлын өвтэй тэмцэх чиглэлээр соёлын өвийг хадгалах, хамгаалах, эрэн сурвалжлах нэгжийг цагдаагийн хэсэг дээр байгуулагдсан байгаа. Энэхүү ЮНИДРУАгийн конвенцыг баталснаар илүүтэй соёлын өв хил дамнан гарсан, хууль бусаар экспортлогдсон тохиолдолд хууль, эрх зүйн хүрээнд илүү боловсронгуй болж, буцаан төвлөрүүлэх боломжийг илүү нэмэгдүүлж байгаа.

Цаашлаад мөн таны асуусан дотоодын хууль, эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай байгаа юу гэдэг асуултад хариулахад тийм байгаа. Бид бүхэн ирэх оны 2025 онд өргөн барих гэж байгаа хууль бол Соёлын өвийн багц хуулийг өргөн барих гэж байгаа. Үүн дээрээ илүү дэлгэрэнгүй энэ соёлын өвийн хадгалалт, хамгаалалт мөн хил дамнан гарах, хууль бус экспорт дээр анхаарахаар дотоод зохицуулалтаа нэмэгдүүлж байгаа. Дэлгэрэнгүй нэмэлт өвийн талаар хариултыг манай Соёлын өвийн газрын дарга Даваацэрэн хариулна.

**Б.Энх-Амгалан:** Нэмээд Даваацэрэн дарга хариулъя. 3 номерын микрофоныг өгье. Наадах чинь өөрөө асчихна, хариулаарай.

**Б.Даваацэрэн:** Энх-Амгалан даргын асуултад хариулъя. Мэдээж хэрэг конвенцод нэгдэн орсноор болбол энэ хууль бусаар хулгайлагдсан болон хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлийг буцаан авахтай холбоотой, эгүүлэн авахтай холбоотой эрх зүйн боломж бол нэмэгдэнэ, өсөн нэмэгдэнэ. Тэгэхдээ энэ конвенц болбол 1970 оны конвенцыг нөхөж гарч ирж байгаа түүнд тусгагдаагүй зохицуулалтуудыг илүү нарийн нарийвчилж тусгачихсанаараа болбол чухал байдаг. Конвенцод нэгдэн орсноор хууль тогтоомжид өөрчлөлт оруулах асуудлыг сайд сая хэллээ.

Энэ дээр нэмээд хэлэхэд конвенцыг соёрхон батлаад, хэрэглэхэд өнөөдөр болбол соёлын өвийг хамгаалахтай холбоотой ямар нэг хууль, баримт бичгүүдтэй зөрчилдөх асуудал байхгүй. Үндсэндээ өнгөрсөн хугацаанд бол энэ конвенцын үзэл санааны хүрээнд холбогдох зохицуулалтуудыг хууль, эрх зүйн хүрээнд болбол бүрэн тусгаж чадсан байгаа. Цаашид болбол нарийвчлаад процессын шинжтэй зохицуулалтуудыг болбол холбогдох хуулиудад тусгаад явах ийм төлөвлөгөөтэй байгаа.

**Б.Энх-Амгалан:** Ажлын хэсгийнхэнд баярлалаа. Тэрнээс гадна бас нэг зүйлийг протоколд тэмдэглэж үлдээе. Соёлын өв, үнэт өв, бурхан шүтээн энэ олон зүйлийг болбол бас хулгайлж гадагш нь гаргах асуудлууд буурахгүй байгаа учраас энэ дээр болбол онцгой анхаарч, Соёлынхоо багц хуульд тусгана гэдэг бол зөв зүйтэй.

Тэрнээс гадна түүх дурсгалын газрууд, соёлын өв хадгалагдсан тийм газар, ялангуяа хадны сүг зураг, бичээстэй ийм газруудад ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгоод байгаа энэ нөхцөлийг Соёлын яам онцгой анхаарч, тэр ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой энэ асуудал дээрээ Соёлынхоо багц хуульд энийг бас оруулж уул уурхайн энэ Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулга дээр энийгээ бас тусгаж

өгөхгүй болбол ЮНЕСКОд бүртгэлтэй газар чинь орчихсон тууж явна лээ шүү. Сая бид нар сонсголоор нэлээн олон зүйлийг харсан. Энийг онцгой анхаараарай. Нэлээн олон, 6 соёлын дурсгалт өв устчихсан байна лээ шүү дээ тийм ээ. Тийм учраас энийг анхаараарай.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дуулаа. Хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүн байна уу? Алга байна. Санал хураалт явуулъя.

Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай ЮНИДРУА-гийн Хувийн эрх зүйг нэгтгэх олон улсын хүрээлэнгийн конвенцыг Соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүдээ. Санал хураалтад 9 гишүүн оролцож, 7 гишүүн

дэмжиж, 77,8 хувийн саналаар уг санал дэмжигдлээ. Хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд миний бие танилцуулъя.

12.07 цаг

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Хуралдаанд идэвхтэй оролцсон Улсын Их Хурлын гишүүдэд болон Ажлын хэсэгт баярлалаа. Хуралдаан өндөрлөлөө.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

БУУЛГАЖ, ХЯНАСАН:

ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА